



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/670

Мөрөн

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах
тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:0

1. Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах, "Хөвсгөл Дулааны станц" ХК, Могойн гол ХК-нд үүссэн нөхцөл байдлыг харгалзан үзэж аймгийн төв дэхь орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн зарим байгууллагын түлш халаалтын зардлын 11, 12 дугаар сарын төсвөөс 335763,0 мянган төгрөгийг хасч, 10 дугаар сарын түлш халаалтын зардлын төсөв дээр нэмэгдүүлэн, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсугай

2. Байгууллагуудын түлш халаалтын зардлын 11, 12 дугаар сарын төсвөөс хасч 10 дугаар сарын төсөвт шилжүүлж зарцуулах жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Төсөвт байгууллагын хуваарьт зохих өөрчлөлтыг тусган, зарцуулалтын эрх нээлгэж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

4. Хуваарийн дагуу болон урьдчилсан байдлаар зарцуулалтын эрхийг нь нээлгэсэн түлш халаалтын зардлыг "Хөвсгөл Дулааны станц" ХК-нд бүрэн шилжүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

5. "Хөвсгөл Дулааны станц" ХК-ны захирал /Д.Мөнхсайхан/-д үүрэг болгох нь:

а/ Төсөвт байгууллагуудын 10-р сарын түлш халаалтын зардлын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж нэмэгдүүлсэн 335763 төгрөгөөр "Могойн гол" ХК-нд үүсгэсэн өрийг барагдуулах

б/ Байгууллагын санхүүгийн удирдлагыг сайжруулахад анхаарч өр авлагыг барагдуулж шинээр өр авлага үүсгэхгүй ажиллах

в. Нүүрс таталтын ажлыг шуурхай зохион байгуулж өвөлжилтийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллах

6. Хөрс хуулалтын ажлыг эрчимжүүлж, нүүрс нийлүүлэлтийг тасралтгүй ханган ажиллахыг Могойн гол ХК-ны захирал Б.Хашбатад үүрэг болгосугай

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

12 1250

Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар
сарын 09-ний өдрийн А/670 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ТӨВ ДЭХ ОН, ТЗШ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТҮЛШ
ХАЛААЛТЫН ЗАРДАЛД ХИЙХ ӨӨРЧЛӨЛТИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөгөөр/

Байгуулага	Түлш халаалтын зардал			
	10 сарын батлагдсан төсөв	10-н сарын төсөв дээр нэмэгдүүлсэн дүн	11 сард үлдсэн төсөв	12 сард үлдсэн төсөв
АЗДТГазар	22,100.0	44,200.0	0.0	0.0
Асрамжийн газар	2,532.0	2,532.3	0.0	0.0
Мөрөн ЗДТГ	5,900.0	15,250.0	0.0	0.0
ХТҮТөв	1,687.5	2,881.0	0.0	0.0
ОН-ын байгууллагуудын дүн	32,219.5	64,863.3	0.0	0.0
ХДТеатр	17,420.0	16,939.0	481.0	17,420.0
Соёлын байгууллагын дүн	17,420.0	16,939.0	481.0	17,420.0
ДМЦСургууль	42,024.7	27,311.0	21,787.4	25,950.9
"Сод-Эрдэм" сургууль	27,000.0	20,000.0	7,000.0	11,100.0
"Титэм" сургууль	35,000.0	20,000.0	10,000.0	5,000.0
ЭДЦСургууль	42,000.0	20,000.0	19,883.7	13,888.2
"Ирээдүй" сургууль	35,000.0	20,000.0	15,000.0	10,000.0
"Гурван-Эрдэнэ" сургууль	17,000.0	10,000.0	7,000.0	11,939.8
"Аваргууд" сургууль	13,660.0	10,000.0	13,660.0	3,660.0
"Авьяас" сургууль	8,000.0	14,952.9	0.0	0.0
ЕБСургуулийн дүн	219,684.7	142,263.9	94,331.1	81,538.9
Мөрөн 1-р цэцэрлэг	3,807.1	7,739.0	0.0	0.0
Мөрөн 2-р цэцэрлэг	6,125.0	12,587.7	0.0	0.0
Мөрөн 3-р цэцэрлэг	6,681.0	11,371.0	0.0	0.0
Мөрөн 4-р цэцэрлэг	6,403.5	6,337.8	0.0	0.0
Мөрөн 5-р цэцэрлэг	6,736.0	13,416.5	0.0	0.0
Мөрөн 6-р цэцэрлэг	5,367.0	9,000.0	0.0	0.0
Мөрөн 7-р цэцэрлэг	8,160.8	17,652.2	0.0	0.0
Мөрөн 8-р цэцэрлэг	2,445.0	4,075.0	0.0	0.0
Мөрөн 9-р цэцэрлэг	5,595.9	9,979.5	0.0	0.0
Мөрөн 10-р цэцэрлэг	4,233.2	9,138.8	0.0	0.0
Мөрөн 11-р цэцэрлэг	3,239.7	5,399.3	0.0	0.0
Мөрөн 12-р цэцэрлэг	5,000.0	5,000.0	0.0	0.0
Цэцэрлэгүүдийн дүн	63,794.2	111,696.8	0.0	0.0
НИЙТ ДҮН	369,174.8	335,763.0	94,812.1	98,958.9